




# МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУССАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ



Улаанбаатар хот  
2024 он

ННА 65  
ДАА 330  
Т-204

## МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУССАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### Боловсруулсан:

Т.Тамир (ШУТИС-ийн багш, Бизнесийн удирдлагын магистр)

© Нээлттэй Нийгэм Форум, 2024

Хаяг: Жамьян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар 14240  
Утас: 76113207  
Веб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

Энэхүү шинжилгээний дүгнэлт нь уг шинжилгээг хийсэн судлаачийн үзэл бодол, байр суурь бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг төлөөлөхгүй.

ISBN 978-9919-9083-8-6

## АГУУЛГА

ОРШИЛ .....	5
НЭГ. Монгол Улсын 2024 оны төсөвт туссан хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн тойм .....	5
ХОЁР. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд туссан болон батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслүүд, Төсвийн ерөнхийлөн захирагчаар .....	10
ГУРАВ. Монгол Улсын 2024 оны төсөвт УИХ-аас нэмж тусгасан хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн судалгаа .....	15
ДҮГНЭЛТ .....	23
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ .....	24
Хавсралт 1. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусаагүй боловч УИХ-аас нэмж баталсан хөрөнгө оруулалтын 63 шилжих төсөл .....	25
Хавсралт 2. Монгол Улсын төсвийн төсөлд туссан боловч 2024 оны төсвийн тухай хуульд тусаагүй хөрөнгө оруулалтын 9 шилжих төслийн мэдээлэл.....	31
Хавсралт 3. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн анхны төсөвт өртөг ба 2024 оны төсөвт өртгийн харьцуулалт.....	32

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын 2024 оны улсын төсвөөр санхүүжүүлэхээр өргөн баригдсан болон батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслийн тооны харьцуулалт .....	6
Зураг 2. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын шилжих төслийн тоо, байршлаар.....	7
Зураг 3. Улсын төсвийн санхүүжилтээр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн төсвийн төсөлд туссан болон батлагдсан төсөвт өртгийн харьцуулалт, төсвийн ерөнхийлөн захирагчаар (тэрбум төгрөг) .	12
Зураг 4. Монгол Улсын 2024 оны төсөвт УИХ-аас нэмж баталсан шилжих төслийн тоо, байршлаар .....	15
Зураг 5. Монгол Улсын төсвийн санхүүжилтээр 2024 онд санхүүжүүлэх шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тоо, төсөл эхэлсэн он .....	22

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх шилжих төслүүд, байршлаар .....	7
Хүснэгт 2. Монгол Улсын төсвөөр 2024 онд улсын хэмжээнд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шилжих төслүүд .....	9
Хүснэгт 3. Улсын төсвийн санхүүжилтээр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийг Төсвийн ерөнхийлөн захирагчаар харьцуулсан байдал.....	10
Хүснэгт 4. Монгол Улсын 2024 оны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх шилжих төслүүдийн төрөл, төсвийн ерөнхийлөн захирагчаар .....	13
Хүснэгт 5. 2024 оны улсын төсвийг батлахдаа УИХ-аас нэмсэн Улаанбаатар хотод байршилтай шилжих төслүүд.....	16
Хүснэгт 6. 2024 оны улсын төсвийг батлахдаа УИХ-аас нэмсэн Өвөрхангай, Завхан аймгуудад байршилтай шилжих төслүүд.....	19
Хүснэгт 7. 2024 оны төсвийн төсөлд туссан боловч 2024 оны төсвийн тухай хуульд тусаагүй хөрөнгө оруулалтын шилжих төслүүд .....	21

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
МУСЗГХЭГД	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга
МУСОНБТСҮХД	Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭХС	Эрчим хүчний сайд

## ОРШИЛ


Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль 2023 оны 11 дүгээр сард батлагдан, 12 дугаар сард ил болсон. Энэхүү судалгаагаар 2024 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтийг авч үзлээ. Энэ хүрээнд Засгийн газраас 2023 оны 9 дүгээр сарын 29-нд Улсын Их Хурал (УИХ)-д өргөн барьсан 2024 оны төсвийн төсөлд туссан болон батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн өөрчлөлтийг судаллаа. Судалгаанд 2024 оны төсвийн төсөлд туссан 552, 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад батлагдсан 606 шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хамрууллаа.

## НЭГ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСӨВТ ТУССАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТОЙМ

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд туссан нийт 1049 төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 52.6 хувь буюу 552 нь шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламж байсан. Эдгээрийн 2024 оны төсөвт өртөг 5.1 их наяд төгрөг, 2024 онд санхүүжүүлэх дүн 1.58 их наяд төгрөг байсан. Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд 552 шилжих төсөл туссан бол төслийн тухай Монгол Улсын хуульд 63 шилжих төсөл (Хавсралт 1) нэмэгдэж, 9 шилжих төсөл (Хавсралт 2) хасагдсантай холбоотойгоор нийт 606 шилжих төсөл батлагджээ. Эдгээрийн 2024 оны нийт төсөвт өртөг 5.6 их наяд төгрөг, 2024 онд санхүүжүүлэх дүн 1.52 их наяд төгрөг байна. Төслүүдийн нийт төсөвт өртөг 500 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

Төсвийн төсөлтэй харьцуулахад барилга байгууламж 50 шилжих төслөөр, их засвар 4 шилжих төслөөр, тоног төхөөрөмж 1 шилжих төслөөр тус тус өссөн бол техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) 1 шилжих төслөөр буурч батлагдсан байна (Зураг 1).

## ЗУРАГ 1. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ УЛСЫН ТӨСВӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР ӨРГӨН БАРИГДСАН БОЛОН БАТЛАГДСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛИЙН ТООНЫ ХАРЬЦУУЛАЛТ



Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан, хөрөнгө оруулалтын шилжих төслийн 91.7 хувийг барилга, байгууламж, 4.2 хувийг их засвар, 3.6 хувийг тоног төхөөрөмж, 0.5 хувийг ТЭЗҮ эзэлж байна (Зураг 1).

Хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийг байршлаар нь авч үзвэл Улаанбаатар хотод хамгийн олон буюу 192 төслийг санхүүжүүлж байгаа бол Дорноговь аймагт хамгийн бага буюу 1 төслийг санхүүжүүлж байна (Зураг 2). Дорноговь аймагт байршилтай 700 хүний суудалтай театрын барилгын төсөл 2021 онд эхэлсэн, 9.5 тэрбум төгрөгийн анхны төсөвт өртөгтэй байсан бол 2024 оны төсөвт өртөг нь 18.5 тэрбум төгрөг болж өсжээ. Уг төсөлд 2024 онд 7 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөжээ.

## ЗУРАГ 2. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛИЙН ТОО, БАЙРШЛААР



Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Улаанбаатар хотод хамгийн олон төсөл буюу 192 шилжих төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад 97 төсөл, Барилга, хот байгуулалтын сайдын багцад 34 төсөл, Эрүүл мэндийн сайдын багцад 16 төслийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Харин Дорноговь аймагт хамгийн бага буюу 1 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь Соёлын сайдын багц дахь 700 суудалтай “Саран хөхөө” театрын барилга байна (Хүснэгт 1).

### ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ШИЛЖИХ ТӨСЛҮҮД, БАЙРШЛААР (ТЭРБУМ ТӨГРӨГ)

Байршил	Төслийн тоо	2024 оны төсөвт туссан төсөвт өртөг	2024 онд олгох санхүүжилт
Улаанбаатар	192	1,893.9	460.6
Төв	23	542.3	118.8
Хэнтий	21	442.5	121.6
Дорнод	19	430.1	103.5
Улсын хэмжээнд	11	355.5	102.4

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Байршил	Төслийн тоо	2024 оны төсөвт туссан төсөвт өртөг	2024 онд олгох санхүүжилт
Хөвсгөл	40	216.2	79.3
Ховд	22	211.6	67.1
Архангай	18	201.4	55.0
Өвөрхангай	39	176.4	55.2
Баянхонгор	27	174.7	54.7
Баян-Өлгий	32	162.2	47.9
Дархан-Уул	10	141.2	25.0
Говь-Алтай	37	126.3	52.3
Увс	22	91.7	34.5
Дундговь	16	77.6	22.3
Булган	14	74.4	32.2
Сэлэнгэ	18	70.3	23.5
Завхан	15	61.2	22.2
Орхон	9	49.7	12.2
Сүхбаатар	9	34.9	10.9
Говьсүмбэр	6	28.6	9.3
Өмнөговь	5	23.9	5.4
Дорноговь	1	18.5	7.0

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Улаанбаатар хотоос гадна, хамгийн олон төсөл, арга хэмжээ, барилга байгууламжтай, хамгийн өндөр төсөвт өртөг, санхүүжилттэй аймгуудыг Төв, Хэнтий, Дорнод, Хөвсгөл, Ховд, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Баян-Өлгий, Дархан-Уул, Говь-Алтай, Увс аймгууд тэргүүлж байна (Хүснэгт 1). Үүнээс гадна, “Улсын хэмжээнд” гэсэн тодотголтой буюу байршил тодорхойгүй 11 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж байна.



ХҮСНЭГТ 2. МОНГОЛ УЛСЫН ТӨСВӨӨР 2024 ОНД УЛСЫН ХЭМЖЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮД (ТЭРБУМ ТӨГРӨГ)

№	Төслийн нэр	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	2024 онд санхүүжүүлэх дүн
1	САНГИЙН САЙД: Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хамт	32.2	114.1	14.5
2	БХБС: Аймгуудын шинэ суурьшлын бүсэд баригдах орон сууцны хорооллын шугам сүлжээ, дэд бүтэц	100.0	109.8	42.7
3	БХБС: Сумын хөгжил, инженерийн дэд бүтцийн хангамж төсөл	45.9	61.8	20.4
4	ХЗДХС: Улсын хил хамгаалалтын зориулалтын инженерийн байгууламжийн шинэчлэлт	17.3	18.3	4.0
5	САНГИЙН САЙД: Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах	8.0	18.0	5.3
6	ЭХС: Сум, суурин газрын цахилгаан хангамж, шугам сүлжээ, дэд станц	12.0	11.8	6.4
7	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР: Улсын ерөнхий прокурорын газрын харьяа байгууллагуудын конторын барилга	7.9	10.3	1.7
8	МУСЗГХЭГД: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын барилгын их засвар	0.5	6.5	6.5
9	БХБС: Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт	35.0	4.1	0.4
10	МУСЗГХЭГД: Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харьяа байгууллагуудын тоног төхөөрөмж	0.4	0.4	0.4
11	БХБС: Нийслэл, аймгийн төвүүдийн үерийн хамгаалалтын шинэчлэлт, зураг төсвийн хамт	15.0	0.2	0.1
<b>Дүн</b>		<b>274.3</b>	<b>355.3</b>	<b>102.4</b>

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Улсын хэмжээнд хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын шилжих төслийн 2024 оны төсөвт өртгийн 37.1 хувь нь Сангийн сайдын багцад, 49.5 хувь Барилга, хот байгуулалтын сайдын багцад, 13.4 хувь нь бусад төслийн ерөнхийлөн захирагч нарт хамаарч байна (Хүснэгт 2).

## ХОЁР. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУССАН БОЛОН БАТЛАГДСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮД, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР

Монгол Улсын 2024 оны төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2024 оны төсөвт өртгийн 25 хувь Боловсрол, шинжлэх ухааны сайдад, 21.6 хувь Зам, тээврийн хөгжлийн сайдад, 12.9 хувь Барилга, хот байгуулалтын сайдад, 7.6 хувь Эрчим хүчний сайдад, 7.4 хувь Соёлын сайдад, үлдсэн 18.9 хувь бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарт оногдож байна (Хүснэгт 3).

### ХҮСНЭГТ 3. УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙГ ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ (ТЭРБУМ ТӨГРӨГ)

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	2024 оны төсөвт өртөг	Нийт төсөвт өртөгт эзлэх хувь	2024 онд санхүүжих дүн
Боловсрол, шинжлэх ухааны сайд	269	1403.8	25.05%	414.4
Зам, тээврийн хөгжлийн сайд	40	1215.2	21.68%	255.8
Барилга, хот байгуулалтын сайд	81	721.4	12.87%	263.3
Эрчим хүчний сайд	20	428.6	7.65%	139.1
Соёлын сайд	42	413.3	7.37%	95.5
Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар, хотын автозамын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга	2	362.9	6.48%	56.2
Эрүүл мэндийн сайд	48	291.9	5.21%	115.8
Монгол Улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга	24	179.1	3.19%	38.2
Сангийн сайд	4	150.2	2.68%	23.5
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	26	122.7	2.19%	38.3
Шүүхийн ерөнхий зөвлөл	1	76.0	1.36%	5.0
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	13	69.5	1.24%	19.4

Хүснэгт 3-ын үргэлжлэл


Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	2024 оны төсөвт өртөг	Нийт төсөвт өртөгт эзлэх хувь	2024 онд санхүүжих дүн
Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	14	55.4	0.99%	26.2
Хууль зүй, дотоод хэргийн сайд	10	52.9	0.94%	17.9
Улсын ерөнхий прокурор	2	16.0	0.29%	1.8
Монгол Улсын шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд	1	15.3	0.27%	4.0
Монгол Улсын шадар сайд	1	12.5	0.22%	3.6
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	3	10.3	0.18%	3.4
Батлан хамгаалахын сайд	3	6.0	0.11%	0.9
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	2	2.1	0.04%	0.7
<b>Нийт</b>	<b>606</b>	<b>5605.1</b>	<b>100%</b>	<b>1523.1</b>

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад хамгийн их буюу 1.4 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламж оногдож байна (Зураг 3). Зам, тээврийн хөгжлийн сайдын багц дахь шилжих төслийн төсөвт өртөг 1.2 их наяд төгрөг, Барилга хот байгуулалтын сайдын багц дахь шилжих төслийн төсөвт өртөг 0.7 их наяд төгрөг байна.

2024 оны төсвийн тухай хуульд туссан хөрөнгө оруулалтын шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2024 оны төсөвт өртөг төсвийн төсөлд туссан дүнгээс өссөн байна (Зураг 3). Хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн нийт төсөвт өртгийн дүнгээр Боловсрол, шинжлэх ухааны сайд тэргүүлж буй бөгөөд 269 төслийн 251 нь сургууль, цэцэрлэгийн барилга барих, засварлах төсөл байна (Хүснэгт 4).

ЗУРАГ 3. УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУССАН БОЛОН БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН ХАРЬЦУУЛАЛТ, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР (ТЭРБУМ ТӨГРӨГ)



Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

ХҮСНЭГТ 4. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН ТӨРӨЛ, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААР

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төрөл	Төслийн тоо
Боловсрол, шинжлэх ухааны сайд	Бага сургууль, дотуур байр, ерөнхий боловсролын сургууль, их сургууль, сургуулийн автобус, цэцэрлэг	251
	Багшийн хөгжлийн төв, боловсролын төв, лаборатори	6
	Хүүхдийн зуслан, спорт цогцолбор, тусгай үйлчилгээ	8
	Дэд бүтэц	4
Зам, тээврийн хөгжлийн сайд	Авто зам, нисэх буудал	38
	Дэд бүтэц	1
	Төрийн үйлчилгээг сайжруулах	1
Барилга, хот байгуулалтын сайд	Гудамж, орон сууц, сум, хүүхдийн тоглоомын талбай, явган хүний замын тохижилт	27
	Дэд бүтэц	48
	Лаборатори, сүм хийд, төрийн үйлчилгээг сайжруулах	6
Эрчим хүчний сайд	Дэд бүтэц	15
	Станц, үйлдвэр, зэвсэгт хүчин	5
Соёлын сайд	Ахмадын төв	1
	Музей, номын сан, соёл урлаг	40
	Спорт цогцолбор	1
Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах үндэсний хорооны дарга	Засаг захиргааны нэгж	1
	Нийтийн тээвэр	1
Эрүүл мэндийн сайд	Ерөнхий боловсролын сургууль	1
	Лаборатори, нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв	47
Монгол Улсын сайд, олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга	Спорт цогцолбор	24
Сангийн сайд	Дэд бүтэц	1
	Тусгай үйлчилгээ	3
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	Ахуйн үйлчилгээний төв	1
	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, лаборатори, тариаланг дэмжих, үйлдвэр, үйлдвэр технологийн парк	25

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төрөл	Төслийн тоо
Шүүхийн ерөнхий зөвлөл	Төрийн үйлчилгээг сайжруулах	1
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	Ахмадын төв, сувилал, спорт цогцолбор	8
	Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв	2
	Төрийн үйлчилгээ, тусгай үйлчилгээг сайжруулах	3
Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	Засаг захиргааны нэгж	11
	Их сургууль	1
	Төрийн үйлчилгээг сайжруулах	2
Хууль зүй, дотоод хэргийн сайд	Дэд бүтэц	1
	Зэвсэгт хүчний анги тохижилт	2
	Төрийн үйлчилгээ, тусгай үйлчилгээг сайжруулах	7
Улсын ерөнхий прокурор	Тусгай үйлчилгээг сайжруулах	2
Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	Дэд бүтэц	1
Монгол Улсын шадар сайд	Тусгай үйлчилгээг сайжруулах	1
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд	Дэд бүтэц, лаборатори, Музей	3
Батлан хамгаалахын сайд	Зэвсэгт хүчин	3
Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	Дэд бүтэц	2
<b>Нийт</b>		<b>606</b>


Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Зам, тээврийн сайдын багцын 40 төслийн 38 нь авто зам, нисэх буудлын төсөл, Барилга, хот байгуулалтын сайдын 81 төслийн 48 нь дэд бүтцийн төсөл, Эрчим хүчний сайдын 20 төслийн 15 нь дэд бүтцийн төсөл, Соёлын сайдын 42 төслийн 40 нь музей, номын сан, соёл урлагийн байгууллагын барилгын төсөл байна (Хүснэгт 4).

## ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСӨВТ УИХ-ААС НЭМЖ ТУСГАСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН СУДАЛГАА

Төсвийн төсөлд туссан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт дээр УИХ-аас 63 шилжих төсөл нэмж (Хавсралт 1), 9 төсөл хасаж баталсан байна (Хавсралт 2). Эдгээр 63 төсөл нь нийт 416.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2024 онд санхүүжих дүн 39.6 тэрбум төгрөг байна. Ийнхүү өмнөх онуудад эхэлсэн 60 гаруй шилжих төслийг Засгийн газраас төсвийн төсөлд тусгаагүй орхигдуулсан нь Төсвийн тухай хуулийн 27.6 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө дараах эрэмбийг баримтална: (i) шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ; (ii) их засвар, засвар арчлалтын төсөл, арга хэмжээ; (iii) шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйг харуулж байна. Өмнөх онуудад эхэлсэн төслүүдэд шаардагдах санхүүжилтийг хуваарилахгүй байх нь төслийн хэрэгжилт удаашрах эрсдэл дагуулах юм.

ЗУРАГ 4. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСӨВТ УИХ-ААС НЭМЖ БАТАЛСАН ШИЛЖИХ ТӨСЛИЙН ТОО, БАЙРШЛААР



Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

УИХ-аас нэмсэн шилжих төслийн тоогоор Улаанбаатар хот тэргүүлж, Өвөрхангай, Завхан аймгууд удаалж байна (Зураг 4). Тухайлбал, Улаанбаатар хотод дараах 20 шилжих төслийг нэмжээ (Хүснэгт 5). Эдгээрийн дотор 10 гаруй жилийн өмнө эхэлсэн төсөл ч байна. Жишээлбэл, БХБС-ийн багц дахь Сонгинохайрхан дүүрэгт байрлалтай Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга нь 2011 онд эхэлсэн бөгөөд 2.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр анх батлагдаж байжээ. Уг төслийн төсөвт өртөг 2024 оны төсвийн тухай хуулиар 8.2 тэрбум төгрөг байхаар батлагдсан нь анхны төсөвт өртгөөсөө 5.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ийнхүү хэрэгжилт нь удааширсан төслүүдийн төсөвт өртөг ихээхэн нэмэгджээ. Түүнчлэн Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт байршилтай Үндэсний номын сангийн барилга 2012 онд эхэлсэн бөгөөд анхны төсөвт өртөг 12 тэрбум төгрөг байсан бол 2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг 26 тэрбум төгрөг болж 13.7 тэрбум төгрөгөөр өсжээ.

#### ХҮСНЭГТ 5. 2024 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙГ БАТЛАХДАА УИХ-ААС НЭМСЭН УЛААНБААТАР ХОТОД БАЙРШИЛТАЙ ШИЛЖИХ ТӨСЛҮҮД (ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР)

№	Төсвийн ерөнхийлөн захирагч / Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	
						Мөнгөн дүнгээр	Хувиар
1	ШЕЗ: Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр	УБ ХУД	2013	15.0	76.0	61.0	407%
2	СОЁЛЫН САЙД: Үндэсний номын сангийн барилга	УБ СБД	2012	12.0	25.7	13.7	114%
3	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	УБ СХД	2018	2.8	9.5	6.7	239%
4	БХБС: Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга	УБ СХД	2011	2.8	8.1	5.3	189%
5	ХНХС: Ахмадын сувиллын барилга	УБ НД	2022	2.6	6.8	4.2	162%



Хүснэгт 5-ын үргэлжлэл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч / Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	
						Мөнгөн дүнгээр	Хувиар
6	БШУС: Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор	УБ ЧД	2022	2.9	6.9	4.0	138%
7	БШУС: Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор	УБ ЧД	2022	2.9	6.7	3.8	131%
8	БХБС: Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны шинэчлэл	УБ НД	2022	5.0	8.4	3.4	68%
9	БШУС: Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга	УБ СХД	2020	3.5	6.7	3.2	91%
10	МУСЗГХЭГД: Хорооны барилга	УБ СХД	2022	2.0	4.8	2.8	140%
11	БШУС: Сургуулийн барилга, 960 суудал	УБ БЗД	2019	6.5	8.7	2.2	34%
12	БШУС: Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор	УБ БЗД	2022	3.6	5.3	1.7	47%
13	БХБС: Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц	УБ СХД	2013	5.0	6.5	1.5	30%
14	БШУС: Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор	УБ БЗД	2020	2.5	3.8	1.3	52%
15	БШУС: Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга	УБ ХУД	2022	4.6	5.8	1.2	26%
16	ЭМС: Эрүүл мэндийн салбарын их засвар-Улсын хоёрдугаар төв эмнэлэг барилгын их засвар	УБ БЗД	2020	0.9	1.6	0.7	78%

№	Төсвийн ерөнхийлөн захирагч / Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	
						Мөнгөн дүнгээр	Хувиар
17	БШУС: Цэцэрлэгийн барилга, 50 ор	УБ БГД	2022	2.0	2.4	0.4	20%
18	ХНХС: Ахмадын хөгжлийн төвийн барилга	УБ БН	2022	0.9	1.2	0.3	33%
19	БШУС: Цэцэрлэг, сургуулиудын гадна талбайн тохижилт, ногоон байгууламж	УБ ЧД	2022	1.0	1.3	0.3	30%
20	БШУС: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоног төхөөрөмж	УБ БЗД	2022	2.2	2.2	0.0	0%

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Өвөрхангай, Завхан аймгуудад байршилтай нийт 13 шилжих төслийг УИХ нэмж баталсан байна (Хүснэгт 6). Эдгээрээс хамгийн олон жил үргэлжилж буй төсөл нь 2019 онд эхэлсэн Соёлын сайдын багц дахь 200 суудалтай соёлын төвийн барилгын төсөл, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад хамаарах, Өвөрхангай аймгийн Тарагт сумын Засаг даргын Тамгын газрын барилгын төсөл байна. Эхний төсөл 1.2 тэрбум, хоёрдох төсөл 1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр анх батлагдаж байжээ. Эдгээр төслийн төсөвт өртөг 2024 оны төсвийн тухай хуулиар 2.1, 1.5 тэрбум төгрөг байхаар тус тус батлагдсан нь анхны төсөвт өртгөөсөө 0.9, 0.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 6. 2024 ОНЫ УЛСЫН ТӨСВИЙГ БАТЛАХДАА УИХ-ААС НЭМСЭН ӨВӨРХАНГАЙ, ЗАВХАН АЙМГУУДАД БАЙРШИЛТАЙ ШИЛЖИХ ТӨСЛҮҮД (ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР)

№	Төсвийн ерөнхийлөн захирагч/ Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
1	БШУС: Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал	Өвөрхангай, Арвайхээр сум	2022	7.4	6.9	-0.5	-7%
2	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор	Завхан, Яруу сум	2022	1.9	3.1	1.2	63%
3	БШУС: Цэцэрлэгийн барилга	Завхан, Тосонцэнгэл сум	2020	1.5	2.7	1.2	80%
4	БХБС: Үерийн далан	Өвөрхангай, Хархорин сум	2022	2.0	2.6	0.6	30%
5	БШУС: Сургуулийн спорт заалны барилга	Завхан, Отгон сум	2022	1.7	2.2	0.5	29%
6	БШУС: Сургуулийн спорт заалны барилга	Завхан, Цагаанхайрхан сум	2022	1.2	2.1	0.9	75%
7	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 200 суудал	Завхан, Түдэвтэй сум	2019	1.2	2.1	0.9	75%
8	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Хужирт сум	2021	1.0	1.7	0.7	70%
9	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Богд сум	2021	1.0	1.6	0.6	60%

Хүснэгт 6-ын үргэлжлэл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч/ Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
10	МУСЗГХЭГД: Засаг даргын Тамгын газрын барилга	Өвөрхангай, Тарагт сум	2019	1.0	1.5	0.5	50%
11	БШУС: Сургуулийн спорт заалны барилга	Завхан, Цагаанчулуут сум	2020	1.1	1.4	0.3	27%
12	БОАЖС: Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга	Өвөрхангай, Хужирт сум	2022	0.4	0.6	0.2	50%
13	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Хайрхандулаан сум	2022	0.3	0.5	0.2	67%

Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд тусгагдаагүй боловч 2024 оны төсвийн тухай хуульд нэмэгдсэн 63 (Хавсралт 1) шилжих төслийг төрлөөр нь авч үзвэл, зам, гүүрний 2 төсөл, ахмадын төв, сувиллын барилгын 2 төсөл, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн барилгын 26 төсөл, дэд бүтцийн 4 төсөл, аймгийн Засаг даргын Тамгын газар, хорооны барилга, тоног төхөөрөмжийн 4 төсөл, лабораторийн барилгын 2 төсөл, аймаг, дүүргийн шүүх, цагдаагийн газрын барилгын 2 төсөл, соёлын төвийн барилгын 5 төсөл, эрүүл мэндийн төвийн барилгын 9 төсөл байгаагаас гадна Ховд аймгийн музейн барилгын төсөл, Баян-Өлгий аймгийн нисэх буудлын барилгын төсөл, үндэсний номын сангийн барилгын төсөл, Улсын II төв эмнэлгийн барилгын төсөл, Налайх дүүрэг дэх, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны шинэчлэх төсөл, Баянхонгор, Төв аймгуудад барих спорт цогцолборын барилгын төслүүд байна.

ХҮСНЭГТ 7. 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУССАН БОЛОВЧ 2024 ОНЫ ТӨСВИЙН  
ТУХАЙ ХУУЛЬД ТУСААГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮД  
(ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР)

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсвийн төсөлд туссан төсөвт өртөг
1	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	УБ, СХД	2018	2.8	9.5
2	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Хужирт сум	2021	1.0	1.7
3	Багийн эрүүл мэндийн төвийн барилга, 5 ор	Баян- Өлгий, Ногооннуур сум	2021	0.2	0.8
4	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Богд сум	2021	1.0	1.6
5	Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга	Баян-Өлгий, Өлгий сум	2022	2.1	2.5
6	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Хайрхандулаан сум	2022	0.3	0.5
7	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил	Хөвсгөл, Мөрөн сум	2022	7.0	7.0
8	“Эрдэнэт” шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл	Орхон, Баян-Өндөр сум	2022	5.0	5.0
9	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	Хөвсгөл, Ховд	2022	3.6	1.4


*Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль*

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд туссан боловч 2024 оны төсвийн тухай хуульд батлагдаагүй 9 (Хавсралт 2) шилжих төсөлд, эрүүл мэндийн төвийн барилгын 5 төсөл, шүүх шинжилгээний лабораторийн 1 төсөл, гэр хорооллын шугам сүлжээний 1 төсөл, 1 ТЭЗҮ, багийн хөгжлийг дэмжих 1 төсөл байна. Эрүүл мэндийн 5 шилжих төслийн 3 нь Өвөрхангай аймагт, 2 төсөл нь Улаанбаатар, Баян-Өлгий аймагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байжээ. Эдгээр төсөл 2018-2022 онд эхэлсэн байна.

2024 оны төсвийн төсөлд туссагүй боловч 2024 оны төсвийн тухай хуульд нэмж баталсан, их засварын 4 шилжих төсөл, тоног төхөөрөмжийн 1 шилжих төсөл байна. Эдгээр 4 шилжих төсөл нь Архангай аймгийн Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар, Хэнтий аймгийн шугам сүлжээний засвар, Чингэлтэй дүүргийн сургууль, цэцэрлэгийн гадна талбайн тохижилт, Улсын төв II эмнэлгийн барилгын их засварын төсөл юм. Эдгээр 4 төслийн анхны төсөвт өртөг дунджаар 53 хувиар өсөж, 2024 оны төсвийн тухай хуульд батлагдсан байна.

2024 оны төсвийн төсөлд тусгагдаагүй боловч УИХ-аас нэмж баталсан 63 төслийн хамгийн урт хугацаанд хэрэгжиж буй төсөл нь 2011 онд эхэлсэн байна (Зураг 5). Энэ төсөл нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт баригдах газар хөдлөлийн сорилын лабораторийн барилга юм. Мөн 11 дэх жилдээ хэрэгжиж буй 2 төсөл байна. Эдгээр төсөл нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн шүүхийн нэгдсэн байр, гэр хорооллын дахин төлөвлөлтийн инженерийн дэд бүтцийн төсөл юм.

#### ЗУРАГ 5. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТЭЭР 2024 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ ШИЛЖИХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТОО, ТӨСӨЛ ЭХЭЛСЭН ОН



Эх сурвалж: Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2024 оны төсвийн төсөлд туссан болон 2024 оны төсвийн тухай хуульд батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн дүн шинжилгээнээс гарсан дүнг тоймлоход дараах байдалтай байна. Үүнд:

- 2024 оны төсвийн тухай хуульд тусгасан шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тоо, 2024 оны төсөвт өртгийн нийт дүн, 2024 онд олгох санхүүжилтийн дүн 2024 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд туссан дүн тус бүрээс өссөн. Хамгийн их өссөн эдийн засгийн ангилал нь барилга байгууламж байна.
- 2024 оны хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд туссан шилжих төсөл дээр УИХ-аас нийт 416.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 63 шилжих төслийг нэмж баталсан байна. Эдгээр шилжих төслийн эхний төсөл 2011 онд эхэлсэн байна. Ийнхүү өмнөх онуудад эхэлсэн 60 гаруй шилжих төслийг Засгийн газраас төсвийн төсөлд тусгаагүй орхигдуулсан нь Төсвийн тухай хуулийн 27.6 дахь заалт буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө шилжих буюу он дамжин хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг нэн тэргүүнд тусгах шаардлагыг хэрэгжүүлээгүйг харуулж байна. УИХ-аас нэмсэн шилжих төслүүдэд 2024 онд 39.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталжээ.
- Хэрэгжилт нь удааширсан төслүүдийн төсөвт өртөг ихээхэн нэмэгдсэнээс гадна өөрчлөлтийн хувь хэмжээ ихээхэн ялгаатай байна.
- Хамгийн олон шилжих төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Аймгуудыг авч үзвэл, Төв аймагт хэрэгжүүлэх шилжих төсөл хамгийн их төсвийг, Хэнтий аймагт хэрэгжүүлэх шилжих төсөлд хамгийн их санхүүжилтийг 2024 онд төсөвлөсөн бол Ховд аймагт хамгийн олон шилжих төслийг 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.
- Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын шилжих төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид бусад төсвийн ерөнхийлөн захирагчтай харьцуулахад хамгийн олон төсөл, их төсөвт өртөг, санхүүжилтийг 2024 онд төлөвлөжээ.
- Дийлэнх төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд 2024 оны төсвийн төсөлд туссан шилжих төслүүдийн төсөвт өртгийн нийт дүн 2024 оны төсвийн тухай хуульд өссөн бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны сайдын шилжих төсөл хамгийн их өссөн байна.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгын төсөл нийт шилжих төсөлд өндөр хувь эзэлж байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. 2024 оны төсвийн тухай Монгол Улсын хууль
2. Монгол Улсын 2024 оны төсвийн төслийн баримт бичиг



# ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСААГҮЙ БОЛОВЧ УИХ-ААС НЭМЖ БАТАЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 63 ШИЛЖИХ ТӨСӨЛ

(тэрбум төгрөгөөр)

№	Төсвийн ерөнхийлөн захирагч/Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
1	ШЕЗ: Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр	УБ ХУД	2013	15.0	76.0	61.0	406%
2	БХБС: Гэр хорооллын цэвэр, бохир ус, дулааны шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил	Хөвсгөл Мөрөн сум	2022	7.0	22.7	15.7	224%
3	СОЁЛЫН САЙД: Үндэсний номын сангийн барилга	УБ СБД	2012	12.0	25.7	13.7	114%
4	ЗТХС: Дархан-Шарын гол чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл	Дархан-Уул Шарын гол сум	2019	41.6	52.4	10.8	26%
5	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	УБ СХД	2018	2.8	9.5	6.7	239%
6	БШУС: Сургуулийн барилга, 320 суудал	Баянхонгор Баянцагаан сум	2019	3.4	9.5	6.1	178%
7	БШУС: Сургуулийн барилга, 640 суудал	Хэнтий Өмнөдэлгэр сум	2020	4.0	9.4	5.4	134%
8	БХБС: Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилга	УБ СХД	2011	2.8	8.2	5.3	190%

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч/Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
9	МУСОНБТСҮХД: Усан бассейн спорт цогцолборын барилга	Баянхонгор Баянхонгор сум	2019	9.0	14.0	5.0	56%
10	БХБС: Сумын төвийн төвлөрсөн дулаан хангамж, цэвэр ус, ариутгах татуургын шугам сүлжээний их засвар	Хэнтий Бор-Өндөр сум	2022	10.0	14.5	4.5	45%
11	БШУС: Спорт, урлагийн цогцолбор сургууль, 320 суудал	Хөвсгөл Мөрөн сум	2020	2.5	7.0	4.5	180%
12	ХНХС: Ахмадын сувиллын барилга	УБ НД	2022	2.6	6.8	4.2	161%
13	БШУС: Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор	УБ ЧД	2022	2.9	7.0	4.0	139%
14	БШУС: Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор	УБ ЧД	2022	2.9	6.7	3.9	135%
15	БШУС: Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга	УБ СХД	2020	3.5	7.0	3.5	99%
16	БХБС: Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны шинэчлэл	УБ НД	2022	5.0	8.4	3.4	68%
17	БШУС: Цэцэрлэгийн барилгын өргөтгөл	Дархан-Уул Дархан сум	2022	2.0	5.3	3.3	166%
18	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 200 суудал	Хөвсгөл Ренчинлхүмбэ сум	2020	1.4	4.6	3.2	229%
19	БШУС: Сургуулийн барилга, 250 суудал	Орхон Баян-Өндөр сум	2018	1.0	4.0	3.0	295%

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч/Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
20	МУСЗГХЭГД: Хорооны барилга	УБ СХД	2022	2.0	4.8	2.8	138%
21	БШУС: Дотуур байрны барилга, 120 ор	Өмнөговь Даланзадгад сум	2022	2.3	4.6	2.3	100%
22	БШУС: Сургуулийн барилга, 960 суудал	УБ БЗД	2019	6.5	8.7	2.2	33%
23	ЗТХС: Өлгий нисэх буудлын өргөтгөлийн барилга	Баян-Өлгий Өлгий сум	2022	2.5	4.6	2.1	83%
24	БШУС: Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 240 ор	УБ БЗД	2022	3.6	5.3	1.7	47%
25	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 200 суудал	Дорнод Булган сум	2020	1.6	3.3	1.7	102%
26	БХБС: Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц	УБ СХД	2013	5.0	6.5	1.5	29%
27	ЗТХС: Хануй голын төмөр бетон гүүр	Архангай Хайрхан сум	2021	3.5	4.9	1.4	41%
28	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 300 суудал	Баян-Өлгий Улаанхус сум	2019	1.1	2.5	1.4	124%
29	БШУС: Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 150 ор	УБ БЗД	2020	2.5	3.8	1.3	52%
30	БШУС: Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга	УБ ХУД	2022	4.6	5.8	1.3	28%
31	БШУС: Цэцэрлэгийн барилга, 50 ор	Баян-Өлгий Булган сум	2021	0.8	1.9	1.2	157%
32	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор	Завхан Яруу сум	2022	1.9	3.1	1.2	62%

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч/Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
33	БШУС: Цэцэрлэгийн барилга	Завхан Тосонцэнгэл сум	2020	1.5	2.7	1.2	79%
34	БШУС: Дотуур байрны барилга, 160 ор	Төв Зуунмод сум	2022	2.1	3.2	1.1	55%
35	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 240 суудал	Дундговь Цагаандэлгэр сум	2019	1.2	2.3	1.1	86%
36	МУСОНБТСҮХД: Спорт заалны барилга	Төв Жаргалант сум	2021	0.6	1.6	1.0	174%
37	БШУС: Сургуулийн спорт заалны барилга	Завхан Цагаанхайрхан сум	2022	1.2	2.1	0.9	72%
38	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 200 суудал	Завхан Түдэвтэй сум	2019	1.2	2.1	0.9	73%
39	ХЗДХС: Цагдаагийн газрын барилга	Архангай Эрдэнэбулган сум	2022	5.4	6.2	0.8	16%
40	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай Хужирт сум	2021	1.0	1.7	0.7	71%
41	БШУС: Сургуулийн спорт заалны барилга	Хэнтий Биндэр сум	2020	0.5	1.2	0.7	149%
42	БХБС: Үерийн далан	Өвөрхангай Хархорин сум	2022	2.0	2.6	0.6	30%
43	ЭМС: Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга	Хөвсгөл Алаг-Эрдэнэ сум	2019	0.5	1.1	0.6	113%
44	ЭМС: Эрүүл мэндийн салбарын их засвар /Улсын хэмжээнд/- Улсын хоёрдугаар төв эмнэлэг барилгын их засвар	УБ БЗД	2020	0.9	1.6	0.6	70%

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч/Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
45	ЭМС: Багийн эрүүл мэндийн төвийн барилга, 5 ор	Баян-Өлгий Ногооннуур сум	2021	0.2	0.8	0.6	382%
46	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай Богд сум	2021	1.0	1.6	0.6	59%
47	БШУС: Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 50 ор	Архангай Тариат сум	2019	0.5	1.1	0.6	124%
48	БШУС: Сургуулийн спорт заалны барилга	Завхан Отгон сум	2022	1.7	2.2	0.5	30%
49	МУСЗГХЭГД: Засаг даргын Тамгын газрын барилга	Өвөрхангай Тарагт сум	2019	1.0	1.5	0.5	48%
50	БШУС: Цэцэрлэгийн барилга, 50 ор	УБ БГД	2022	2.0	2.4	0.4	18%
51	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Увс Давст сум	2022	1.2	1.5	0.4	33%
52	БШУС: Сургуулийн спорт заалны барилга	Завхан Цагаанчулуут сум	2020	1.1	1.4	0.3	25%
53	ХНХС: Ахмадын хөгжлийн төвийн барилга	УБ БНД	2022	1.0	1.2	0.3	30%
54	БШУС: Цэцэрлэг, сургуулиудын гадна талбайн тохижилт, ногоон байгууламж	УБ ЧД	2022	1.0	1.3	0.3	29%
55	МУСЗГХЭГД: Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар	Архангай Ихтамир сум	2021	0.3	0.5	0.2	67%
56	БОАЖС: Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн барилга	Өвөрхангай Хужирт сум	2022	0.5	0.6	0.2	40%

Хавсралт 1-ийн үргэлжлэл

№	Төсвийн ерөнхийлөн захирагч/Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
57	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай Хайрхандулаан сум	2022	0.3	0.5	0.2	82%
58	СОЁЛЫН САЙД: Өв соёл, хүндэтгэлийн өргөө	Ховд Үенч сум	2020	0.2	0.2	0.0	0%
59	БШУС: Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоног төхөөрөмж	УБ БЗД	2022	2.2	2.2	0.0	0%
60	БШУС: Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал	Өвөрхангай Арвайхээр сум	2022	7.4	7.0	(0.5)	-6%
61	БШУС: Цэцэрлэгийн барилга, 75 ор	Ховд Жаргалант сум	2022	2.2	2.1	(0.1)	-4%
62	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Ховд Мянгад сум	2022	2.0	1.8	(0.2)	-10%
63	МУСЗГХЭГД: Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмж	Хөвсгөл	2022	3.6	1.4	(2.2)	-61%

## ХАВСРАЛТ 2. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУССАН БОЛОВЧ 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ТУСААГҮЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 9 ШИЛЖИХ ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

(тэрбум төгрөгөөр)

№	Төслийн нэр	Байршил	Эжэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсвийн төсөлд туссан төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
1	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг	2018	2.8	9.5	6.7	239%
2	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Хужирт сум	2021	1.0	1.7	0.7	71%
3	Багийн эрүүл мэндийн төвийн барилга, 5 ор	Баян-Өлгий, Ногооннуур сум	2021	0.2	0.8	0.6	381%
4	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Богд сум	2021	1.0	1.6	0.6	59%
5	Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга	Баян-Өлгий, Өлгий сум	2022	2.1	2.5	0.4	19%
6	Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл	Өвөрхангай, Хайрхандулаан сум	2022	0.3	0.5	0.2	82%
7	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажил	Хөвсгөл, Мөрөн сум	2022	7.0	7.0	0.0	0%
8	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн паркийн техник, эдийн засгийн үндэслэл	Орхон, Баян-Өндөр сум	2022	5.0	5.0	0.0	0%
9	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	Хөвсгөл, Ховд	2022	3.6	1.4	-2.2	-61%

## ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД БАТЛАГДСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЛЖИХ ТӨСЛҮҮДИЙН АНХНЫ ТӨСӨВТ ӨРТӨГ БА 2024 ОНЫ ТӨСӨВТ ӨРТГИЙН ХАРЬЦУУЛАЛТ

А. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслүүд: 2010-2015 онд эхэлсэн төслүүд

(тэрбум төгрөгөөр)

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
1	МУСОНБТСҮХД: Дүүргийн спорт цогцолбор, 1000 суудал	УБ БЗД	2010	2.6	13.6	11.0	431%
2	МУСОНБТСҮХД: Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал	УБ НД	2010	1.9	15.0	13.1	697%
3	СОЁЛЫН САЙД: "Төв халх" дуулалт жүжгийн театр	Дундговь Сайнцагаан сум	2011	6.8	10.5	3.7	55%
4	СОЁЛЫН САЙД: Хөгжимт жүжгийн театрын барилга, 800 суудал	Завхан Улиастай сум	2011	3.0	19.4	16.4	547%
5	МУСОНБТСҮХД: Спорт цогцолбор, 2200 суудал	Дархан-Уул Дархан сум	2011	11.0	36.4	25.3	229%
6	БШУС: Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилга	УБ БЗД	2012	4.0	5.3	1.3	32%
7	СОЁЛЫН САЙД: Аймгийн хөгжимт драмын театрын барилга	Архангай Эрдэнэбулган сум	2012	7.1	21.0	13.9	195%
8	БШУС: ХААИС-ийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн хичээлийн байр	Орхон Баян-Өндөр сум	2013	2.2	10.6	8.4	388%
9	БХБС: Сумын төвийн шинэчлэл	Хэнтий Биндэр сум	2014	5.0	5.4	0.4	9%
10	БШУС: Цэцэрлэгийн барилга, 150 ор	Орхон Баян-Өндөр сум	2014	1.3	1.6	0.4	30%



Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
11	МУСОНБТСҮХД: Дүүргийн спорт цогцолбор, 700 суудал	УБ БГД	2014	6.4	10.0	3.7	57%
12	ХНХС: Усан спорт цогцолбор	УБ СХД	2014	5.0	17.2	12.2	245%
13	БХБС: Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д Ш800-ийн гол шугамыг Ш1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын ажил /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3.4 км/	УБ СХД	2014	15.6	39.7	24.0	154%
14	БШУС: Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжих Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн барилга төслийн Монголын талын хөрөнгө	УБ БЗД	2015	12.9	23.0	10.1	78%

Б. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслүүд: 2018-2019 онд эхэлсэн төслүүд

(тэрбум төгрөгөөр)

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
1	БШУС: Спорт заалны барилга	Орхон Баян-Өндөр сум	2018	0.8	0.8	-	0%
2	БШУС: Цэцэрлэгийн барилга, 200 ор	Сүхбаатар Эрдэнэцагаан сум	2018	2.2	2.2	-	0%

Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
3	БХБС: Нийслэл, аймгийн төвүүдийн инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт	Улсын хэмжээнд	2018	35.0	4.1	(30.9)	-88%
4	БХБС: Нийслэл, аймгийн төвүүдийн үерийн хамгаалалтын шинэчлэлт, зураг төсвийн хамт	Улсын хэмжээнд	2018	15.0	0.3	(14.7)	-98%
5	БШУС: Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 240 ор /66 дугаар цэцэрлэг/	УБ БГД	2018	2.5	2.1	(0.4)	-16%
6	ХХААХҮС: Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн барилга	Говьсүмбэр Сүмбэр сум	2018	2.2	2.4	0.2	9%
7	БХБС: Халуун ус, ахуйн үйлчилгээний төвийн барилга	Дундговь Цагаандэлгэр сум	2018	0.3	0.4	0.2	65%
8	БШУС: Цэцэрлэгийн барилга, 75 ор	Сэлэнгэ Орхонтуул сум	2018	0.9	1.2	0.3	37%
9	МУСОНБТСҮХД: Оюуны спортын ордны барилга	УБ ХУД	2018	4.0	4.3	0.3	7%
10	БШУС: Цэцэрлэгийн барилга, 280 ор	УБ СБД	2018	2.1	2.6	0.5	25%
11	БШУС: Сургуулийн барилга, 920 суудал	УБ БЗД	2018	6.6	7.1	0.5	8%
12	БШУС: Сургуулийн барилга, 640 суудал	УБ СХД	2018	4.4	5.1	0.7	15%
13	ЭМС: Сэргээн засах төвийн барилга, 36 ор	УБ ХУД	2018	4.0	4.9	0.9	23%
14	БШУС: Цэцэрлэгийн барилга, 100 ор	Говь-Алтай Халиун сум	2018	0.9	2.0	1.1	122%
15	БШУС: Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал	Говь-Алтай Дэлгэр сум	2018	2.1	3.5	1.4	66%
16	БШУС: Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга	УБ ЧД	2018	2.0	3.6	1.6	82%

Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
17	БШУС: Сургуулийн барилга, 640 суудал	УБ СХД	2018	5.6	7.1	1.6	28%
18	БШУС: Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал	УБ БГД	2018	3.8	5.8	1.9	50%
19	БШУС: Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал	УБ СБД	2018	1.5	4.1	2.6	170%
20	БШУС: Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал	УБ ЧД	2018	4.0	6.8	2.8	70%
21	БШУС Сургуулийн барилга, 320 суудал	Хөвсгөл Чандмань-Өндөр сум	2018	3.6	6.8	3.2	88%
22	БШУС Сургуулийн барилга буулгаж, шинээр барих, 640 суудал	УБ БГД	2018	3.3	7.9	4.6	142%
23	БШУС Цэцэрлэгийн барилга, 200 ор	Сүхбаатар Баяндэлгэр сум	2019	2.1	2.1	-	0%
24	БШУС Сургуулийн барилгын өргөтгөл	Сэлэнгэ Мандал сум	2019	3.8	3.8	-	0%
25	МУСОНБТСҮХД Усан бассейн, спорт фитнесийн барилга	Увс Улаангом сум	2019	4.1	4.1	-	0%
26	БШУС: Цэцэрлэгийн барилга, 100 ор	Хөвсгөл Төмөрбулаг сум	2019	1.2	1.2	-	0%
27	БОАЖС: Хиймэл дагуулын мэдээ хүлээн авах газрын станцын антены цамхгийн байр	УБ	2019	5.2	5.1	(0.2)	-3%
28	ХНХС: Залуучуудын хөгжлийн төвийн барилга	УБ СБД	2019	2.5	2.3	(0.2)	-10%
29	ЗТХС: Аймгийн төвийн хатуу хучилттай зам, 2.8 км хүртэл	Увс Улаангом сум	2019	2.0	1.9	(0.1)	-3%
30	ЗТХС: Аймгийн төвийн 4 дүгээр тойргийн хатуу хучилттай авто зам, 9.1 км	Сүхбаатар Баруун-Урт сум	2019	5.7	5.7	0.0	1%

Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
31	ЗТХС: Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, дугуйн зам, 5.5 км	Дорнод Хэрлэн сум	2019	10.9	10.9	0.0	0%
32	ЗТХС: Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 3 км	Завхан Их-Уул сум	2019	2.0	2.0	0.0	1%
33	БШУС: Цэцэрлэгийн А байрны барилгыг буулгаж, шинээр барих	УБ ХУД	2019	2.4	2.4	0.0	0%
34	БШУС: Дотуур байрны барилга	Баян-Өлгий Цэнгэл сум	2019	1.6	1.6	0.0	0%
35	БШУС: Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор	Говьсүмбэр Сүмбэр сум	2019	1.6	1.6	(0.0)	0%
36	ЗТХС: Хувьсгалчдын гудамжнаас хорооны цогцолбор хүртэлх авто зам, 0.9 км	УБ СХД	2019	0.9	0.9	(0.0)	-3%
37	СОЁЛЫН САЙД: Солийн Данзаны нэрэмжит музей, цэцэрлэгт хүрээлэн	Архангай Хотонт сум	2019	1.0	1.1	0.1	14%
38	ЗТХС: Ривер Хиллс хотхоноос Зайсангийн гудамж хүртэлх хатуу хучилттай авто зам, зогсоол, 1 км	УБ ХУД	2019	1.5	1.6	0.1	5%
39	БШУС: Цэцэрлэгийн барилга, 200 ор	УБ БГД	2019	2.0	2.2	0.2	12%
40	БШУС: Бага сургуулийн барилга	Төв Бүрэн сум	2019	1.2	1.5	0.3	26%
41	МУСОНБТСҮХД: Спорт заалны барилга	Дундговь Говь-Угтаал сум	2019	1.0	1.3	0.3	28%
42	МУСЗГХЭГД: Хорооны цогцолбор барилга	УБ СХД	2019	1.4	1.6	0.3	20%
43	ЗТХС: Сумын төвийн хатуу хучилттай авто зам, 2 км	Дундговь Эрдэнэдалай сум	2019	1.8	2.1	0.3	14%
44	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 200 суудал	Завхан Нөмрөг сум	2019	1.2	1.6	0.4	31%
45	ЭМС: Өрхийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга	УБ БЗД	2019	1.6	2.0	0.4	23%

Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
46	БШУС: Сургуулийн барилга, 320 суудал	УБ СБД	2019	3.7	4.1	0.4	9%
47	БШУС: Цэцэрлэгийн барилга, 150 ор	УБ ЧД	2019	1.3	1.8	0.5	42%
48	БШУС: Дотуур байрны барилга, 150 ор	Дорнод Цагаан-Овоо сум	2019	1.5	2.0	0.5	31%
49	МУСОНБТСҮХД: Спорт заалны барилга	Говь-Алтай Бигэр сум	2019	0.3	0.7	0.5	182%
50	БШУС: Цэцэрлэгийн барилга, 75 ор	Говь-Алтай Алтай сум	2019	0.9	1.5	0.6	72%
51	БШУС: Цэцэрлэгийн барилга, 75 ор	Говь-Алтай Дэлгэр сум	2019	0.9	1.5	0.6	69%
52	БШУС: Цэцэрлэгийн барилга, 75 ор	Говь-Алтай Цээл сум	2019	0.9	1.5	0.6	67%
53	МУСОНБТСҮХД: Спорт заалны барилга	Говь-Алтай Бугат сум	2019	0.3	1.0	0.7	281%
54	БШУС: Сургуулийн барилга, 640 суудал	Баянхонгор Баянхонгор сум	2019	5.2	6.0	0.8	16%
55	ЭМС: Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор	Баян-Өлгий Өлгий сум	2019	0.3	1.0	0.8	301%
56	МУСОНБТСҮХД: Спорт заалны барилга	Говь-Алтай Цогт сум	2019	0.3	1.2	0.9	375%
57	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 240 суудал	Өвөрхангай Баянгол сум	2019	1.2	2.1	0.9	73%
58	БШУС: Сургуулийн барилга, 320 суудал	Хөвсгөл Цэцэрлэг сум	2019	3.5	4.6	1.1	31%
59	БШУС: Сургуулийн барилга, 640 суудал	Увс Наранбулаг сум	2019	3.9	5.1	1.2	31%
60	БШУС: Сургуулийн барилга, 320 суудал	Өмнөговь Цогт-Овоо сум	2019	3.5	4.7	1.2	33%
61	БШУС: Сургуулийн барилга, 640 суудал	Дорнод Хэрлэн сум	2019	4.0	5.4	1.4	36%

Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
62	БШУС: Цэцэрлэгийн барилга, 150 ор	Дорнод Хэрлэн сум	2019	1.5	2.9	1.4	93%
63	БШУС: Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор	Говь-Алтай Төгрөг сум	2019	0.9	2.3	1.4	155%
64	ЭМС: Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор	Дундговь Сайнцагаан сум	2019	8.8	10.1	1.4	16%
65	БШУС: Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 150 ор	УБ БЗД	2019	1.6	2.9	1.4	88%
66	СОЁЛЫН САЙД: Музейн барилга	Дорнод Хэрлэн сум	2019	3.0	4.5	1.5	49%
67	СОЁЛЫН САЙД: Соёлын төвийн барилга, 240 суудал	Хөвсгөл Арбулаг сум	2019	1.2	2.9	1.7	138%
68	БШУС: Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор	Говь-Алтай Жаргалан сум	2019	0.9	2.7	1.8	197%
69	БШУС: Бага сургуулийн барилга, 360 суудал	Баян-Өлгий Цэнгэл сум	2019	1.2	3.1	1.9	154%
70	ЗТХС: Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их Тамир чиглэлийн гүүр, авто замын ажлын эхлэл, 63 км	Архангай Батцэнгэл сум	2019	69.0	71.1	2.1	3%
71	БШУС: Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 240 суудал	УБ ЧД	2019	2.5	4.9	2.4	97%
72	ЭМС: Ахмад настан, хүүхдийн эмнэлгийн барилга	УБ БЗД	2019	7.0	9.4	2.4	35%
73	БШУС: Сургуулийн барилга, 480 суудал	УБ СХД	2019	3.3	6.2	2.9	87%
74	БШУС: Сургуулийн барилга, 640 суудал	Сүхбаатар Эрдэнэцагаан сум	2019	5.0	8.5	3.5	69%
75	БШУС: Сургуулийн барилга, 720 суудал	УБ СБД	2019	6.0	9.7	3.6	60%
76	БШУС: Сургуулийн барилга, 320 суудал	Архангай Цахир сум	2019	3.2	7.1	3.9	121%

Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
77	БШУС: Сургуулийн өргөтгөлийн барилга, 320 суудал	Сэлэнгэ Сүхбаатар сум	2019	3.1	7.1	4.0	129%
78	ЗТХС: Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км	Төв Мөнгөнморьт сум	2019	48.0	52.1	4.1	9%
79	БХБС: Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем	УБ ХУД	2019	4.0	8.4	4.4	110%
80	ЭХС: Хөшөөтийн уурхайгаас Ховд аймгийн Үенч сум хүртэл 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, Үенч дэд станцын өргөтгөл	Ховд Үенч сум	2019	21.2	26.6	5.4	26%
81	БШУС: Сургуулийн барилга, 640 суудал	Баян-Өлгий Өлгий сум	2019	5.0	10.6	5.6	112%
82	ЭМС: Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн өргөтгөлийн барилга	Баянхонгор Баянхонгор сум	2019	3.8	9.5	5.7	153%
83	ЭХС: Тайширын усан цахилгаан станцаас аймгийн төв рүү татах 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц	Говь-Алтай	2019	7.9	14.6	6.7	85%
84	БШУС: Сургуулийн барилга, 960 суудал	Хөвсгөл Тариалан сум	2019	4.0	11.2	7.2	180%
85	СОЁЛЫН САЙД: Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга	Увс Улаангом сум	2019	6.8	15.4	8.6	126%
86	МУСОНБТСҮХД: Соёл, спорт цогцолборын барилга	Хөвсгөл Мөрөн сум	2019	2.0	10.9	8.9	445%
87	СОЁЛЫН САЙД: Дүүргийн соёлын ордны барилга	УБ СХД	2019	8.5	18.0	9.5	111%
88	ЭМС: Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор	Баян-Өлгий Өлгий сум	2019	8.8	28.7	19.9	227%
89	САНГИЙН САЙД: Гаалийн шинэчлэл-Гаалийн ерөнхий газар, газар, хороодын шуурхай удирдлагын төв, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, дэд бүтцийн хамт	Улсын хэмжээнд	2019	32.2	114.1	81.9	255%

В. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд батлагдсан хөрөнгө оруулалтын шилжих төслүүд: 2020 онд эхэлсэн төслүүд

(тэрбум төгрөгөөр)

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
1	БШУС: Дотуур байрны барилгын их засвар	Завхан Отгон сум	2020	0.4	0.4	-	0%
2	САНГИЙН САЙД: Татварын хэлтсийн барилга	УБ, Хөвсгөл, Увс, Баянхонгор	2020	15.9	15.4	(0.5)	-3%
3	ЗТХС: Хороолол доторх авто замын засвар	УБ БГД, 5, 6, 7, 9 дүгээр хороо	2020	4.7	4.4	(0.3)	-7%
4	БХБС: Орон сууцны гадна тохижилт	УБ СБД, 7, 8, 9, 10 дугаар хороо	2020	2.0	1.9	(0.1)	-3%
5	ЗТХС: Сумын төвийн хатуу хучилттай авто зам	Ховд Жаргалант сум	2020	0.9	1.0	0.0	5%
6	БШУС: Бага сургуулийн барилгын өргөтгөлийн их засвар	Хөвсгөл Арбулаг сум	2020	0.2	0.2	(0.0)	-1%
7	БШУС: Шинээр баригдсан цэцэрлэг, соёлын төвийн дэд бүтэц, халаалтын зуух	Говь-Алтай Цээл сум	2020	0.2	0.2	(0.0)	-3%
8	БШУС: Бага сургууль, дотуур байрны барилгын өргөтгөлийн их засвар	Хөвсгөл Цэцэрлэг сум	2020	0.2	0.2	(0.0)	-7%
9	ЭМС: Сумын эрүүл мэндийн төвийн барилга	Ховд Алтай сум	2020	0.7	0.7	(0.0)	-5%
10	БШУС: Сургуулийн барилгын өргөтгөл	Архангай Хашаат сум	2020	1.0	1.1	0.1	15%
11	ЗТХС: Сумын төвийн бетон авто зам, 8.3 км	Хөвсгөл Тариалан сум	2020	10.3	10.4	0.1	1%
12	ЗТХС: Тоосгоны 20 дугаар гудамжнаас Хангай зах хүртэлх хатуу хучилттай авто зам, 1 км	УБ СХД	2020	1.5	1.6	0.1	7%
13	БХБС: Гэр хорооллын гудамж, зам, талбайн гэрэлтүүлэг, камержуулалт	УБ СХД	2020	1.0	1.1	0.1	9%



Хавсралт 3-ын үргэлжлэл

№	Төслийн нэр	Байршил	Эхэлсэн он	Анхны төсөвт өртөг	2024 оны төсөвт өртөг	Төсөвт өртгийн өөрчлөлт	Төсөвт өртгийн өөрчлөлт (хувь)
14	ЗТХС: Хорооллын авто замын шинэчлэл, өргөтгөл	УБ ЧД	2020	2.0	2.1	0.1	5%
